



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/185/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил
ХА	үйлчилгээ худалдан авах
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.ОРХОНЦЭЦЭГ ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/185/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж 14,806.5 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	169,525,728.58	255,474,618.53
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	83,976,405.88	138,326,037.51
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	83,976,405.88	138,326,037.51
3121	Төгрөг	83,976,405.88	138,326,037.51
31211	Төрийн сангийн харилцах	83,976,405.88	138,326,037.51
33	АВЛАГА		
35	БАРАА МАТЕРИАЛ	85,549,322.70	117,148,581.02
351	Түүхий эд материал	1,284,000.00	1,284,000.00
3513	Эм боох материал	1,284,000.00	1,284,000.00
354	Хангамжийн материал	84,265,322.70	115,864,581.02
3541	Бичиг хэргийн материал	2,692,250.00	2,678,500.00
3546	Хүнсний материал	914,494.00	796,904.00
3547	Бусад хангамжийн материал	80,658,578.70	112,389,177.02
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	839,577,523.13	920,189,325.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	839,577,523.13	920,189,325.92
392	Биет хөрөнгө	828,165,023.02	904,900,996.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	857,377,385.00	857,377,385.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-111,832,875.39	-132,627,526.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66,418,528.64	103,023,828.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,925,644.63	-12,422,860.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,729,131.50	73,601,131.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,180,770.45	-13,764,592.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	30,128,801.40	36,378,801.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,210,319.05	-9,325,955.97
39217	Ном	2,660,786.00	2,660,786.00
393	Биет бус хөрөнгө	11,412,500.11	15,288,328.95
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-687,499.89	-937,499.85
39303	Бусад биет бус хөрөнгө	10,850,000.00	14,975,828.80
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,009,103,251.71	1,175,663,944.45
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,009,103,251.71	1,175,663,944.45
51	Засгийн газрын хувь оролцоо	1,009,103,251.71	1,175,663,944.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	497,363,823.00	497,363,823.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн	497,363,823.00	497,363,823.00
512	Хуримтлагдсан үр дүн	417,500,251.39	584,060,944.13
5121	Өмнөх үеийн үр дүн	326,988,122.74	417,500,251.39
5122	Тайлант үеийн үр дүн	90,512,128.65	166,560,692.74
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,239,177.32	94,239,177.32
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,009,103,251.71	1,175,663,944.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	955,307,303.69	1,460,398,672.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,503,664.69	153,271,458.72
120	Нийтлэг татварын бус орлого	25,503,664.69	153,271,458.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	19,922,794.69	127,105,960.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,510,870.00	26,130,498.32
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	929,803,639.00	1,307,127,214.01
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	850,377,500.00	1,242,755,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	850,377,500.00	1,242,755,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,426,139.00	64,371,614.01
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,426,139.00	64,371,614.01
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	864,434,476.33	1,293,837,979.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	864,434,476.33	1,293,837,979.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,449,076.33	1,284,213,779.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	560,961,544.29	899,200,192.61
210101	Үндсэн цалин	383,563,770.10	535,263,391.01
210102	Нэмэгдэл	142,937,530.83	321,980,541.54
210104	Урамшуулал	34,460,243.36	41,956,260.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,590,138.66	112,498,897.76
210201	Тэтгэврийн даатгал	49,939,139.68	77,341,802.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,875,193.01	9,099,035.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,590,154.30	4,503,317.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,107,238.44	4,312,948.50
210205	Эрүүл мэндийн даатгал	11,078,413.23	17,241,793.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,956,139.00	60,901,614.01
210301	Гэрэл, цахилгаан	9,866,807.51	9,812,419.06
210302	Түлш, халаалт	50,317,651.49	50,365,834.95
210303	Цэвэр, бохир ус	771,680.00	723,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал		35,000.00
210401	Бичиг хэрэг		35,000.00
2105	Нормативт зардал	102,501,858.00	124,255,765.00
210502	Хоол, хүнс	102,501,858.00	124,255,765.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,475,100.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	5,475,100.00	3,470,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,460,400.00	3,558,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,460,400.00	3,558,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,503,896.38	80,293,910.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,744,713.00	18,141,203.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,561,200.00	10,096,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,197,983.38	52,056,457.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,985,400.00	9,624,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,985,400.00	9,624,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,985,400.00	9,624,200.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		0.00
213304	Хөрөнгийн		0.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.00
	Дотоод эх үүсвэрээр		0.00
222001	Тоног төхөөрөмж		0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	90,872,827.36	166,560,692.74
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	360,698.71	
	Хөрөнгө худалдсаны гарз	360,698.71	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(360,698.71)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	90,512,128.65	166,560,692.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	929,873,639.00	1,307,162,214.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,000.00	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	929,803,639.00	1,307,127,214.01
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	850,377,500.00	1,242,755,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	850,377,500.00	1,242,755,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,426,139.00	64,371,614.01
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,426,139.00	64,371,614.01
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	846,136,538.95	1,247,250,282.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	846,136,538.95	1,247,250,282.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	827,151,138.95	1,243,188,382.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	560,961,544.29	899,200,192.61
210101	Үндсэн цалин	383,563,770.10	535,263,391.01
210102	Нэмэгдэл	142,937,530.83	321,980,541.54
210104	Урамшуулал	34,460,243.36	41,956,260.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,590,138.66	112,498,897.76
210201	Тэтгэврийн даатгал	49,939,139.68	77,341,802.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,875,193.01	9,099,035.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,590,154.30	4,503,317.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,107,238.44	4,312,948.50
210205	Эрүүл мэндийн даатгал	11,078,413.23	17,241,793.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,956,139.00	60,901,614.01
210301	Гэрэл, цахилгаан	9,866,807.51	9,812,419.06
210302	Түлш, халаалт	50,317,651.49	50,365,834.95
210303	Цэвэр, бохир ус	771,680.00	723,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал		35,000.00
210401	Бичиг хэргийн материал		35,000.00
2105	Нормативт зардал	99,774,504.00	124,138,175.00
210502	Хоол, хүнс	99,774,504.00	124,138,175.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,475,100.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	5,475,100.00	3,470,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,460,400.00	3,558,400.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,460,400.00	3,558,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,933,313.00	33,823,803.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,552,113.00	23,741,303.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,381,200.00	10,082,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,985,400.00	9,624,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,985,400.00	9,624,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,985,400.00	9,624,200.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	83,737,100.05	59,911,931.63
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,624,200.00	5,562,300.00
	Дотоод эх үүсвэрээр	20,624,200.00	5,562,300.00
	Барилга байгууламж	4,344,400.00	
	Тоног төхөөрөмж	16,099,800.00	5,562,300.00
	Бусад хөрөнгө	180,000.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(20,624,200.00)	(5,562,300.00)
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	63,112,900.05	54,349,631.63
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,863,505.83	83,976,405.88
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	83,976,405.88	138,326,037.51

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	497,363,823.00	94,239,177.32	417,500,251.39	1,009,103,251.71
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			166,560,692.74	
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	497,363,823.00	94,239,177.32	584,060,944.13	1,175,663,944.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,394,777,800.00	1,252,812,582.38	141,965,217.62	89.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,394,777,800.00	1,252,812,582.38	141,965,217.62	89.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,385,153,600.00	1,243,188,382.38	141,965,217.62	89.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,019,945,100.00	899,200,192.61	120,744,907.39	88.2
210101	Үндсэн цалин	656,056,000.00	535,263,391.01	120,792,608.99	81.6

210102	Нэмэгдэл	332,854,600.00	321,980,541.54	10,874,058.46	96.7
210104	Урамшуулал	31,034,500.00	41,956,260.06	-10,921,760.06	135.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,980,700.00	112,498,897.76	6,481,802.24	94.6
210201	Тэтгэврийн даатгал	80,909,100.00	77,341,802.00	3,567,298.00	95.6
210202	Тэтгэмжийн даатгал	9,516,300.00	9,099,035.52	417,264.48	95.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,759,100.00	4,503,317.83	255,782.17	94.6
210204	Ажилгүйдлийн даатгал	4,759,100.00	4,312,948.50	446,151.50	90.6
210205	Эрүүл мэндийн даатгал	19,037,100.00	17,241,793.91	1,795,306.09	90.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,257,000.00	60,901,614.01	6,355,385.99	90.6
210301	Гэрэл, цахилгаан	15,808,400.00	9,812,419.06	5,995,980.94	62.1
210302	Түлш, халаалт	50,365,700.00	50,365,834.95	-134.95	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,082,900.00	723,360.00	359,540.00	66.8
2104	Хангамж, бараа материалын зардал		35,000.00	(35,000.00)	
210401	Бичиг хэргийн материал		35,000.00	(35,000.00)	
2105	Нормативт зардал	129,113,300.00	124,138,175.00	4,975,125.00	96.1
210502	Хоол, хүнс	129,113,300.00	124,138,175.00	4,975,125.00	96.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,470,000.00		100.0
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00		100.0
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,558,400.00	3,558,400.00		100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,558,400.00	3,558,400.00		100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,829,100.00	39,386,103.00	3,442,997.00	92.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,746,600.00	29,303,603.00	3,442,997.00	89.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,082,500.00	10,082,500.00		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,624,200.00	9,624,200.00		100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,624,200.00	9,624,200.00		100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,624,200.00	9,624,200.00		100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,394,777,800.00	1,252,812,582.38	141,965,217.62	89.8
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,242,755,600.00	1,242,755,600.00		100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,242,755,600.00	1,242,755,600.00		100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	81,295,200.00			0.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	70,727,000.00	64,371,614.01	6,355,385.99	91.0
132001	Орон нутгийн төсвөөс	70,727,000.00	64,371,614.01	6,355,385.99	91.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		35,000.00	-35,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00	-35,000.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		83,976,405.88	-83,976,405.88	

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	138,326,037.51	-138,326,037.51
----	---	----------------	-----------------

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хамтын оролцоонд суурилан цэцэрлэгийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж чанарт ахиц гаргана.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- СӨБ-ыг бүрэн эзэмшүүлэх агуулга бүхий сургалтын төлөвлөгөөг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”-ийг хэрэгжүүлж, багшийн хөгжлийн хэрэгцээг судлан үндэсний болон орон нутгийн ажлын байран дээрх сургалтад хамруулж багш нарын мэргэжил ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх;
- Хүүхдүүдийг эх орноороо бахархах, хайрлах, хамгаалах үндэсний уламжлалт ёс заншилд сурган зөв монгол иргэнийг төлөвшүүлнэ;
- Хүүхэд бүрийг байгаль орчноо хайрлан хамгаалах зан үйлд сурган эрүүл аюулгүй ногоон эко орчныг бүрдүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам” ;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,009,103.3 мянган төгрөг болж өмнөх оноос 166,560.6 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	83,976.4	138,326.0	54,349.6
Авлага			
Бараа материал	85,549.3	117,148.6	31,599.3
Үндсэн хөрөнгө	839,577.5	920,189.3	80,611.8
Нийт хөрөнгө	1,009,103.3	1,175,663.9	166,560.6
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,009,103.3	1,175,663.9	166,560.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,009,103.3	1,175,663.9	166,560.6

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 138,326.0 мянган төгрөг болж 54,349.6 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас;
- Бараа материал дансны үлдэгдэл 117,148.6 мянган төгрөг болж 31,599.3 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаас суманд эрх шилжүүлж 24,587.5 мянган төгрөгийн, сумын ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 1,105.0 мянган төгрөгийн, замын хөдөлгөөний тэмдэг, Адра Монгол ОУБ-аас 438.0 мянган төгрөгийн нийт 26,130.5 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 153,653.9 мянган төгрөгийн худалдан авалт хийж, үйл ажиллагаанд 148,185.1 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас шалтгаалжээ.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,089,267.8 мянган төгрөг болж 71,853.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 5,562.3 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж худалдан авч, суманд эрх шилжсэн аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 42,670.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Адра Монгол ОУБ-аас 9,750.0 мянган төгрөгийн хүлэмж, хөрс сийрүүлэгч, аймгийн Боловсролын газраас 9,745.0 мянган төгрөгийн техник хэрэгсэл, зөөврийн компьютер, 4,125.8 мянган төгрөгийн үнэлгээтэй албан хэрэгцээний газар, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр 60,815.1 мянган төгрөгөөр дахин үнэлсэн зэрэг нийт 127,105.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 169,078.5 мянган төгрөг бөгөөд 920,189.3 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 851,558.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 63,484.1 мянган төгрөг, нийт 915,042.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 89,649.7 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 8,772.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,114.0 мянган төгрөгөөр буюу нийт 102,536.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хүүхдийн хоолны зардлыг 57,617.0 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 1,530.0 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 40,321.8 мянган төгрөгөөр, тэтгэмж урамшууллын зардлыг 5,165.4 мянган төгрөгөөр нийт 106,356.0 мянган төгрөгөөр бууруулж 911,222.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 7 удаа төсвийн зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 1,242,755.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 70,727.0 мянган төгрөгийн, оны эхний үлдэгдлээс 81,295.2 мянган төгрөгөөр нийт **1,394,777.8** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 413,926.3 мянган төгрөгөөр,
- Хүүхдийн хоолны зардлыг 40,268.8 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 3,558.4 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 15,719.1 мянган төгрөгөөр,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 10,082.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн гэх мэт .

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 1,394,777.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 1,252,812.6 мянган төгрөгийг зарцуулж, 138,326.0 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,252,812.6 мянган төгрөг буюу 89.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 136,980.1 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 4,975.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/							
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801 Сургуулийн	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,221.0	2,231.5	10.5	100.5

өмнөх боловсрол	2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	129,113.3	124,138.2	(4,975.1)	96.1
	3	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,915.1	3,915.1	-	100.0
	4	81823- Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	2,221.0	1,960.0	(261.0)	88.2
	5	81834- Боловсролын стандарт сургалт	1,138,626.1	1,008,241.9	(130,384.2)	88.5
	6	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	46,337.1	46,337.1	-	100.0
	7	80233-Хүүхэд хамгаалал				
	8	80111- Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	70,727.0	64,371.6	(6,355.4)	91.0
	Нийт			1,394,777.8	1,252,812.6	(141,965.2)

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол	88,844.5	88,844.5	НТШ
Нийт дүн		88,844.5	88,844.5	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн./ -ыг 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Хүүгийн хишиг” ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 03-ний өдөр гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн /цаашид Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Пийк Ом Аудит" ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 8,638,844.8 мянган төгрөгөөс 1,0 хувиар буюу 8,638.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх

зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг 2 удаа;
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 2 удаа;

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит “ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 906 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,703.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	2,703.9	2	2,703.9	100.0
Нийт дүн	2	2,703.9	2	2,703.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 34,908.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Худалдан авсан 5,562.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа материалын зардлаар бүртгэж тусгасан;
- Үндсэн хөрөнгийн тайлант жилийн элэгдлийн зардлыг санхүүгийн тайланд 29,346.2 мянган төгрөгөөр дутуу тусгасан;

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 21,874.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 5,118.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 16,756.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Жилийн туршид шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг 6 багшид тус бүр 15-20.0 хувиар тооцон 5,118.0 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “*Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 **Илрүүлэлт**: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 16,756.3 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна..

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 **Өгсөн зөвлөмж:** Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн тайлант жилийн зардлыг санхүүгийн тайланд дутуу тусгасан	1	29,346.2			1	29,346.2	1	29,346.2				
Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийг бараа материалын зардлаар бүртгэж тусгасан	1	5,562.3			1	5,562.3	1	5,562.3				
Нийт	2	34,908.5			2	34,908.5	2	34,908.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж олгоогүй	1	5,118.0	1	5,118.0								
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1	16,756.3					1	16,756.3				
Дүн	2	21,874.3	1	5,118.0			1	16,756.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Дүн	1	-	-	-		-	1	-



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 19/A.1850385

Сүхбаатар

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Жилийн туршид шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг хавсралтад дурдсан 6 багшид тус бүр 15-20 хувиар тооцон 5,118.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан


43250505

“Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-т “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.3.2: Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ур чадварны нэмэгдэлд илүү олгосон 5,118.0 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Ц.Орхонцэцэг, нягтлан бодогч О.Мөнх-Од нарт даалгав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.НАРАНЧИМЭГ

2025 оны 02 сарын 25 өдрийн
19/А.1850385 дугаар актын 1 дүгээр хавсралт

**Ур чадварын нэмэгдэл илүү олгосон
багш нар**

/мянган төгрөгөөр/

№	Албан хаагчдын нэрс	Мөнгөн дүн
1	У.Гэрэлтуяа	1,350.0
	О.Мөнгөнзул	384.0
2	Э.Оюун-Эрдэнэ	1,295.0
3	Л.Тогтох	384.0
4	С.Болормаа	378.0
5	О.Бадамханд	1,327.0
	Нийт дүн	5,118.0

Албан шаардлага, төлбөрийн актын бүртгэл, хяналтын хуудас

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл хяналт

1. Үндсэн мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	СЭА-2025/185-НА-СТА-ТШЗ		
1.3 Аудит хийх үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит		
1.5 Албан шаардлага, төлбөрийн актын дугаар/А СЭА-2025/185-НА-СТА-ТШЗ	1.6 Тогтоосон огноо	2/24/2025	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	5,118,000.0

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Зөрчил дутагдлыг товч тодорхойлж бичих		Жилийн туршид шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг хавсралтад дурдсан 6 багшид тус бүр 15-20 хувиар тооцон илүү олгосон		
	Алдаа, зөрчлийн ангилал		Төлбөрийн акт		
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)		Журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"		
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль		
		Заалт	6.4.24		
		Нэр	Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан тушаал		
Заалт	1 дүгээр хавсралт				
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хууль, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам",			
	Заалт	Хуулийн 21.2, журмын 4.2.3, 4.2.3.3,			

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд		5,118,000.0	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд			
	Тухайн байгууллагын дансанд			
				6/15/2025

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Цалингийн баримт,		2024 он	
2	Эрхлэгчийн тушаал		2024 он	

3 Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

Аудитын багийн		Хариуцагч			
Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих утас
Б.Наранчимэг	Аудитор	Баянгол сумын СӨБ	Эрхлэгч	Ц.Орхонцэцэг	99089146
			Нягтлан бодогч	О.Мөнх Од	99027640

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал, зөвлөмж	Гарын үсэг
1	Аудитын менежер	2/25	—	
2	Тэргүүлэх аудитор			

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор			

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар	
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо	2/24/2025	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр	Баянгол сумын СӨБ	
		Ажилтны	Овог нэр	О.Мөнх Од
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Байгууллагын нэр	Пийк Ом аудит ХХК	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөж		